



2021 оны 09 дүгээр сарын 24
№36 /1186/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦ᠋ᠷᠢᠶᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ

ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 94

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 11.3, 269.3, 269.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Шүүхийн зарим төрлийн шийдвэрийг гүйцэтгэхэд хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, нөхөн төлүүлэх, санхүүжүүлэх, төлбөрөөс чөлөөлөх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Х.НЯМБААТАР

Засгийн газрын 2021 оны 94 дүгээр
тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ЗАРИМ ТӨРЛИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭХЭД ХУВИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТЕХНИК ХЭРЭГСЭЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ АШИГЛАХТАЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫГ ТООЦОХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ТӨЛБӨРӨЭС ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167 дугаар зүйлд заасан зорчих эрх хязгаарлах ял оногдуулсан болон мөн хуулийн 189 дүгээр зүйлд заасан үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд техникийн хяналт тавихад гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахтай холбогдон гарах зардлыг тооцох, санхүүжүүлэх, нөхөн төлүүлэх, төлбөрөөс чөлөөлөхөд энэ журмыг баримтална.

1.2.Энэ журмын 1.1-д заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын данс, бүртгэл, тайлан тэнцлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 299.4-т заасан журамд нийцүүлэн хөтөлнө.

1.3.Шийдвэр гүйцэтгэгч нь энэ журмын 2.3-т заасан зардлыг тооцох, бүртгэлийг хөтлөх үүрэгтэй ба түүний үйл ажиллагаанд ахлах шийдвэр гүйцэтгэгч хяналт тавина.

Хоёр.Зардал тооцох, санхүүжүүлэх

2.1.Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд техникийн хяналт тавихад гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж ашигласан зардалд дараах зардлыг хамааруулна:

2.1.1.үүрэн холбооны сүлжээний (сим карт, дата, зурвас илгээх) ашиглалтын зардал;

2.1.2.гар, хөл болон биеийн бусад хэсэгт зүүж ашиглах хяналтын тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал.

2.2.Энэ журмын 2.1-д заасан хувийн өмчит хуулийн этгээдийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг тухайн хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнд заасан хувь, хэмжээгээр тооцож, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 269.3-т заасны дагуу улсын төсвөөс санхүүжүүлнэ.

2.3.Шийдвэр гүйцэтгэгч нь энэ журмын 2.1-д заасан зардлыг дараах аргачлалаар тооцно:

2.3.1.тоног төхөөрөмжийг ашиглах хугацааны зардлыг хоногоор;

2.3.2.хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг тухайн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаанд харьцуулж, сүлжээний хоногийн зардлыг нэмж, ял эдлэх хоногт үржүүлэн.

2.4.Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольсон, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлсөн бол хяналтын тоног төхөөрөмжийн ашигласан хугацааны зардлыг 2.3.2-т заасны дагуу тооцно.

2.5.Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэхэд ашиглаж байгаа тоног төхөөрөмж нь ялтнаас шалтгаалаагүй устсан, гэмтсэн, эсхүл

хэвийн ажиллагаа сарнисан, дахин ашиглах боломжгүй болсон бол тоног төхөөрөмжийг даруй сольж, ашигласан хугацааны зардлыг энэ журмын 2.3.2-т заасны дагуу тооцно.

2.6.Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаа болон үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189.10-т заасны дагуу техникийн хяналт тавихад ашигласан тоног төхөөрөмжийг санаатайгаар устгасан, гэмтээсэн, эсхүл хэвийн ажиллагааг сарниулж, дахин ашиглах боломжгүй болгосон бол хуульд заасан хариуцлага ногдуулж, холбогдон гаргах зардлыг тооцон ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан болон бусад гэм буруутай этгээдээр төлүүлнэ.

2.7.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 173 дугаар зүйлд заасны дагуу зорчих эрх хязгаарлах ял эдлүүлэх нөхцөл, журмыг түр өөрчилсөн тохиолдолд уг хугацааны хяналтын тоног төхөөрөмж ашигласны зардлыг ялтан хариуцна.

2.8.Тухайн жилийн тоног төхөөрөмжийн зардлын 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг цахим бугуйвч, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн нөөц бүрдүүлэлтэд зарцуулна.

Гурав.Зардлыг нөхөн төлүүлэх

3.1.Ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ журмын 2.3-т заасны дагуу тооцсон зардлын тооцооллыг үндэслэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг нөхөн төлүүлэх шийдвэр гаргана.

3.2.Энэ журмын 2.3, 2.4, 2.5-д заасан зардлыг хоног, сар, улирал, жилээр тооцон ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдээр нөхөн төлүүлнэ.

3.3.Энэ журмын 2.6-д заасан зардал, хохирлыг ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд, эсхүл гэм буруутай этгээдээр даруй нөхөн төлүүлнэ.

3.4.Энэ журмын 3.1-д заасан шийдвэрт нөхөн төлүүлэх зардал, хохирлын хэмжээ, нөхөн төлөх үүрэг бүхий этгээдийн овог, нэр, зардал төвлөрүүлэх данс, хугацаа, нөхөн төлөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар тусгана.

3.5.Шийдвэр гүйцэтгэгч зардал, хохирол нөхөн төлүүлэх тухай шийдвэрийг үүрэг хүлээлгэсэн этгээдэд хүргүүлж, тогтоосон хугацаанд биелүүлэх мэдэгдэх хуудсыг гардуулж, тэмдэглэлээр баталгаажуулна.



3.6.Зардал, хохирлыг нөхөн төлөх шийдвэрийг биелүүлэх үүрэг хүлээсэн этгээд ялын хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө зардлыг бүрэн барагдуулсан байна.

3.7.Шийдвэр гүйцэтгэгч зардал, хохирлын мөнгийг бэлнээр хүлээн авах бол тухай бүр баримт үйлдэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107.4-т заасны дагуу байгууллагын дансанд шилжүүлнэ.

3.8.Зардал, хохирлын мөнгийг хүлээн авах санхүүгийн баримт нь нэгдсэн дугаар бүхий хэвлэмэл маягт байна.

3.9.Шийдвэр гүйцэтгэгч зардал, хохирлын мөнгө хүлээн авсан баримтыг 3 хувь үйлдэж, санхүүгийн баримтанд болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хяналтын хувийн хэрэгт хавсарган, 1 хувийг мөнгө тушаасан этгээдэд олгоно. Бэлэн мөнгө хүлээн авсан баримт нь засваргүй байна.

3.10. Ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд зардал, хохирлыг нөхөн төлөх шийдвэрийг энэ журмын 3.2, 3.3, 3.6-д заасан хугацаанд биелүүлээгүй тохиолдолд ялын болон албадлагын арга хэмжээ дууссанаас хойш 30 хоногийн дотор зардал, хохирлын төлбөрийг нөхөн төлүүлэх асуудлыг шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар гүйцэтгүүлнэ.

3.11.Ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд тогтоосон хугацаанд зардлыг нөхөн төлөөгүйгээс энэ журмын 3.10-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бол холбогдох зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага санхүүжүүлсэн дансанд зардлыг буцаан төвлөрүүлнэ.

3.12.Өсвөр насны хүний энэ журмын 2.1-д заасан зардлыг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хариуцна.

3.13.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хяналтын тоног төхөөрөмжийн зардлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 169.1-д заасны дагуу нөхөн төлөхөд энэ журамд заасны дагуу зардлыг тооцож, нөхөн төлүүлнэ.



Дөрөв.Зардлын төлбөрөөс чөлөөлөх

4.1.Энэ журмын 2.1.2-т заасан зардлаас ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг дараах үндэслэлээр чөлөөлж болно:

4.1.1.асран хамгаалах хүнгүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 60 ба түүнээс дээш насны;

4.1.2.эрх бүхий байгууллагаас хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан нь тогтоогдсон ялтан, этгээд;

4.1.3.амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх;

4.1.4.гурав хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх;
4.1.5.бүтэн өнчин хүүхэд.

4.2.Шийдвэр гүйцэтгэгч нь энэ журмын 4.1-д заасан этгээдийн хүсэлт, засаг захиргааны нэгжийн тодорхойлолт, эрх бүхий байгууллагын дүгнэлт, шаардлагатай бусад баримтыг үндэслэн зардлын төлбөрөөс чөлөөлүүлэх саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргана.

4.3.Энэ журмын 4.2-т заасан нөхцөл байдлыг тогтоосон дүгнэлтийг үндэслэн хяналтын тоног төхөөрөмжийн зардлаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.

4.4.Ахлах шийдвэр гүйцэтгэгч санал, холбогдох баримт бичгийг хянаж зардлын төлбөрөөс чөлөөлөх, эсхүл татгалзсан шийдвэрийг гаргана.

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1.Зардал, хохирлын мөнгийг энэ журмыг зөрчин хүлээн авсан, зориулалт бусаар зарцуулсан, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ашиглаж байгаа тоног төхөөрөмжийг үрэгдүүлсэн, гэмтээсэн, дур мэдэн бусдад шилжүүлсэн гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2.Энэ журмын 5.1-д заасан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 100

Улаанбаатар
хот

Дүрэм шинэчлэн батлах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын хилийн тухай хуулийн 29.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хилийн боомтын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 21 дүгээр хавсралтын “Сангийн яамны ажилтан (орон тооны)” гэснийг “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний томилсон албан хаагч” гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 139 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

Засгийн газрын 2021 оны 100 дугаар
тогтоолын хавсралт

ХИЛИЙН БООМТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хилийн боомтыг хөгжүүлэх бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий Хилийн боомтын үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх)-ийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг энэ дүрмээр зохицуулна.

1.2.Үндэсний зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хилийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг удирдлага болгоно.



1.3. Үндэсний зөвлөл нь зохих журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Үндэсний зөвлөл нь Монгол Улсын хилийн тухай хуулийн 29.2-т заасан бүрэлдэхүүнтэй байх ба бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

2.2. Үндэсний зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна. Нарийн бичгийн даргыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

2.3. Нарийн бичгийн дарга нь Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тасралтгүй байдал, ажлын уялдаа холбоог хангаж ажиллана.

2.4. Үндэсний зөвлөл нь энэ дүрмийн 3.10-т заасан чиг үүрэг бүхий ажлын албыг нарийн бичгийн даргын удирдлагад ажиллуулж болно.

2.5. Ажлын албаны орон тоо, ажиллах журмыг Үндэсний зөвлөлийн даргын саналыг үндэслэн Үндэсний зөвлөлийн хурлаар батална.

2.6. Үндэсний зөвлөлийн Ажлын албаны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төсөл, хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлж болно.

Гурав.Хуралдаан

3.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг танхимаар, шаардлагатай тохиолдолд цахимаар зохион байгуулна. Үндэсний зөвлөлийн гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.2. Үндэсний зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Цахим хуралдаанаас гарсан шийдвэр нь ердийн журмаар гарсан шийдвэрийн нэгэн адил хүчин төгөлдөр байна.

3.3. Үндэсний зөвлөлийн даргын эзгүйд түүний эрх олгосноор улсын хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хуралдааныг удирдаж болно.

3.4. Үндэсний зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд оролцох боломжгүй бол хуралдаанд цахимаар оролцох, эсхүл хэлэлцэх асуудлын талаарх саналаа бичгээр гаргаж болно.

3.5. Шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлийн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулж болно.

3.6. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

3.7. Үндэсний зөвлөл нь бүрэн эрхийнхээ хүрээнд хуралдаанаас тогтоол, зөвлөмж гаргана. Үндэсний зөвлөлийн тогтоол, зөвлөмжид дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.8. Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлнө. Тэмдэглэлд нарийн бичгийн дарга, Үндэсний зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

3.9. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуралдаанд саналын эрхгүй оролцож дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.9.1. хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гаргаж Үндэсний зөвлөлийн даргаар батлуулах;

3.9.2. хуралдааны бэлтгэлийг хангаж, хэлэлцүүлэх асуудалтай холбогдох баримт бичгийн бүрдлийг хангах;

3.9.3. хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг 3-аас доошгүй хоногийн өмнө Үндэсний зөвлөлийн гишүүдэд хүргүүлж хуралдааны товыг мэдэгдэх;

3.9.4. хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй гишүүний бичгээр ирүүлсэн саналыг хуралдаанд танилцуулах;

3.9.5. хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдаанаас гарсан шийдвэрийн төслийг албажуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан Үндэсний зөвлөлийн гишүүдэд хүргүүлэх.

3.10. Ажлын алба нь Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, хуралдаанд хэлэлцэх асуудлын техник, эдийн засгийн тооцоо, судалгааг гаргах, Үндэсний зөвлөлийн шийдвэр, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй.

Дөрөв.Үндэсний зөвлөлийн бүрэн эрх

4.1.Үндэсний зөвлөл нь Монгол Улсын хилийн тухай хуулийн 29.4-т зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.хилийн хяналтын байгууллагуудаас ирүүлсэн боомтыг хөгжүүлэх, боомтын дэд бүтэц, хөрөнгө оруулалтын талаарх санал, санаачилгыг хүлээн авч хэлэлцэх, шаардлагатай бол уг асуудлаар тогтоол, зөвлөмж гаргах;

4.1.2.боомтын дэд бүтцийн байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын талаар тогтоол, зөвлөмж гаргах;

4.1.3.хилийн боомтыг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний болон Үндэсний зөвлөлийн тогтоол, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;

4.1.4.хилийн боомтыг хөгжүүлэх асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;

4.1.5.хилийн хяналтын байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, ажлын үр дүн, тайланг тогтоосон хугацаанд хүлээн авч хэлэлцэн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж өгөх;

4.1.6.хилийн хяналтын байгууллагуудаас гадаад худалдааны тээврийн үйл ажиллагаанд хийж буй хяналт шалгалт, төрийн үйлчилгээг уялдуулах, нэгдсэн зохицуулалтаар хангах талаар зөвлөмж гаргах.

Тав.Бусад зүйл

5.1.Үндэсний зөвлөл нь хууль, энэ дүрэмд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хилийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалтын чиг үүрэгт оролцох, хөндлөнгөөс нөлөөлөх, шийдвэр гаргахыг хориглоно.

5.2.Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбоотой байгууллагын нууцад хамаарах асуудлыг задруулах, хуралдааны шийдвэр баталгаажих хүртэл аливаа мэдээллийг бусдад тараахыг хориглоно.

5.3.Үндэсний зөвлөлөөс гаргасан шийдвэрийг төрийн бусад байгууллага холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийг хангах чиглэлээр дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авах, ажлын уялдаа холбоог хангаж хамтран ажиллах үүрэгтэй.



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2021 оны 06 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 12.15 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Солонго, Д.Одбаяр, Б.Буяндэлгэр /илтгэгч/, Ш.Солонго, Ц.Нанзаддорж, Г.Баясгалан, Ж.Эрдэнэбулган нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Баяраа, Б.Мэргэн, Х.Сэлэнгэ нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, мөн Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлтийн тухай” 02 дугаар тогтоолыг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Ариунболд Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл гаргасан байна. Үүнд:

“1. Эрүүгийн хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хууль тогтоогчоос Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлан гаргажээ. Тодруулбал, уг хуулийн 1, 2 дугаар зүйлд зааснаас үзэхэд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр прокурорын тогтоол, шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон “Авлигын гэмт хэрэг”-ээс бусад гэмт хэргүүд сэргээн шалгагдахгүй ажээ. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлээр тогтоогдсон зарчим юм. Гэтэл хүн ямар гэмт хэрэг үйлдсэн, шалгагдаж байснаас шалтгаалж тухайн хүнд



Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль өөрөөр үйлчлэхээр хууль тогтоосон байгаа нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд шууд харшилж байна.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтлах тухай уг хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээх” гэсэн 32.8 дугаар зүйл, “Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл” гэсэн 41.1 дүгээр зүйлд зааснаар прокурор, шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг дахин хянах үндэслэл болдог. Дээрхээс үзэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баримтлах тухай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заагаагүй байна. Нэгэнт тухайн харилцааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан, уг хуульд заагаагүй байхад Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээх талаар тус хуульд заасан нь Үндсэн хуульд заасан “хууль дээдлэх” зарчимд үл нийцэж байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасан. Энэ үүднээс хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг шүүх зөвхөн өөрөө хуульд заасан үндэслэл журмын дагуу шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянан үзэх эсэхээ шийдвэрлэдэг. Гэтэл Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээн шалгах тухай шууд заасан байгаа нь Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ, Улсын Их Хурлын гишүүн, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гэсэн Үндсэн хуулийн заалтад нийцэхгүй байна. Хууль тогтоох замаар Улсын Их Хурлын гишүүн нь шүүгчээс шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцож болохгүй, Улсын Их Хурал хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож болохгүй гэж үзнэ.

4. Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгээр хуулийг дагаж мөрдөх журмаар ямар асуудлыг шийдвэрлэхийг заасан байдаг. Дээрх хуулийн зохицуулалтаас үзэхэд хууль дагаж мөрдөх журмын тухай хууль гэдэг нь эрх зүйн харилцаанд оролцогчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн, хамгаалсан, сөрөг үр дагаврыг арилгах зорилгыг өөртөө агуулах бөгөөд шилжилтийн үеийн харилцааг зохицуулдаг ажээ. Энэ нь Үндсэн хуулийн “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм

цогцлуулан хөгжүүлэх” эрхэм зорилго юм. Гэтэл Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар урьд нэгэнт үүссэн харилцааны эрх зүйн байдлыг дордуулсан, хүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн эрүүгийн хуулийн зарчмыг хэрэглэхгүй байхаар тогтоосон байна.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангах төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг илрэл нь хүний эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй байх эрх зүйн хэм хэмжээ юм. Гэвч гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа өөрчлөгдсөнтэй холбогдуулан хөөн хэлэлцэх хугацааны талаарх хүний эрх зүйн байдлыг дордуулсан заалт нь хүний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийн хэм хэмжээнд хамаарахгүй байхаар заасан нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд үл нийцнэ.

6.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасан. Энэхүү зарчим Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.” гэж тусгасан.

Иймд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал ... -ыг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсгийн “Хүнийг ... нийгмийн ... байдал ... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, 2 дахь хэсгийн “... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.”, мөн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Улсын Их Хурлын ... гишүүн, төр ... бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.” гэсэнд нийцсэн эсэх болон Үндсэн хуулийн “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.” гэж заасанд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн Э.Түмэнбаяр, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 7 дугаар багийн оршин суугч, иргэн М.Мэндбаяр, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 13 дугаар багийн оршин суугч, иргэн М.Ганзориг нар Үндсэн хуулийн цэцэд хандан:

“Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж дараах үндэслэлээр мэдээлэл гаргаж байна. Үүнд:

1.Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.” гэжээ. Гэтэл Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2 дугаар зүйл нь олон улсын гэрээний дээрх заалттай нийцэхгүй байна. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэж үзэж байна. Учир нь шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэхээр төрийн эрх мэдлийг Үндсэн хуулиар хуваарилалт хийсэн. Уг эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын гаргасан тодорхой хэрэг болон маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шийдвэр нь заавал биелэгдэхээр Үндсэн хуулиар хуульчилсан байна.

2.Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэг үйлдэх үед нь дотоодын хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт эс тооцож байсан ямар нэг үйлдэл буюу эс үйлдлээр хэнийг ч гэмт хэрэгтэн гэж буруутгаж болохгүй түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш тийм хэргийн ялыг хуулиар хөнгөлсөн бол уг хэрэгтэнд тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ.” гэж заасан. Гэтэл Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйл нь дээрх заалттай нийцэхгүй байна. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх гэдэг нь шинээр батлагдсан хуулийг дагаж мөрдөгдөхөөс өмнө үйлдэгдсэн гэмт хэрэгт шинэ болон урьд үйлчилж байсан хуулиудын аль хөнгөнийг хэрэглэх явдал бөгөөд ех post facto буюу шинэ хуулийг түүнээс өмнөх үйл баримтад хэрэглэх гэсэн зарчмыг удирдлага болгодог.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зарим заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын

гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. ...” гэж тус тус заасныг зөрчсөн эсэх талаар маргаан үүсгэж, хянан шийдвэрлэж өгнө үү.” гэсэн агуулга бүхий мэдээллийг гаргасан байна.

Гурав. Нийслэлийн Баянгол дүүргийн 12 дугаар хорооны оршин суугч, иргэн Х.Сэлэнгэ Үндсэн хуулийн цэцэд хандан:

“1.Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны үүднээс: Эрүүгийн эрх зүйн хөгжлийн түүхэнд Эрүүгийн хуульд тусгагдсан хөөн хэлэлцэх хугацааны дагуу хэрэгсэхгүй болгосон ямар ч хэргийг сэргээн шалгаж шийдвэрлэсэн туршлага, онол, практик байхгүй байна. Мөн эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглодог онол, практик түүхэндээ байхгүй юм. Энэ үндсэнд аливаа гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь Эрүүгийн хуульд заагдсан тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын дээд хэмжээнээс хамаарч тогтоогддог нийтлэг шинж байна. Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх тухай заалт нь эрүүгийн эрх зүйн энэрэнгүй ёсны зарчмын үүднээс гэмт этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх, мөн ялыг хүндрүүлэхгүй байх тухай ойлголт бөгөөд хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэгдсэн эрүүгийн эрх зүйн суурь зарчим юм. Иймд Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны болон хууль буцаан хэрэглэхтэй холбоотой заалтыг процессын эрх зүйн үүднээс зохицуулах хууль тогтоох нь хууль тогтоох үйл ажиллагааны гажуудлыг илэрхийлж байна. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх эрх зүйн хүрээнд парламентаас баталсан хүчин төгөлдөр хуулийн зүйл заалтыг үндэслэл болгож, шүүх өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох эрх аль ч улс орны хууль тогтоох байгууллагад байхгүй юм.

2.Харьцуулсан эрх зүй судлалын үүднээс: Эрүүгийн эрх зүйн түүхэн хөгжил болон улс орнуудын Эрүүгийн хууль, эрүүгийн процессын хуулийг судалж үзэхэд хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болгосон хэргийг буцаан сэргээх, Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон заалт нэг ч байхгүй байна. Улс орнууд Эрүүгийн хуульдаа хөөн хэлэлцэх хугацаа хэзээ эхэлж, хэзээ зогсох болон түдгэлзэх, хэзээ дуусах, ямар гэмт хэрэгт хэрэглэхгүй байхыг нарийвчлан зохицуулж байна. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Япон Улс, Оросын Холбооны Улс зэрэг гадаадын улс орнуудын Эрүүгийн хуульд гэмт этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахгүйн үүднээс эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэх, эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхийг хориглосон заалтыг тусгасан байна. Мөн аль ч улс оронд хууль тогтоох байгууллагаас баталсан хүчин төгөлдөр Эрүүгийн хуульд заасан хөөн



хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтад үндэслэн шүүх нь өөрийн эрх мэдлийн хүрээнд хэрэгсэхгүй болгосон шүүхийн хүчин төгөлдөр тогтоолыг хүчингүй болгодог туршлага, эрх зүйн шинжлэх ухааны ойлголт, практик байхгүй.

3.Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс: Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх нэрийн дор ардчилсан улс орнуудын болон эрх зүйн түүхэнд байдаггүй хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргүүдийг сэргээх зохицуулалтыг хуульчилж, хүний эрхэд эрх зүйн бусаар халдах боломжийг бий болгосноор эрх зүйн суурь зарчмыг зөрчиж, хүний эрхэд хууль бусаар халдаж, Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... эрх чөлөө ... -г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ..." гэсэн заалтыг зөрчсөн. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2 дугаар зүйлд прокурор, шүүхээс хүчин төгөлдөр Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны эрх зүйн зохицуулалтын дагуу хэрэгсэхгүй болгосон хэргүүдийн хүчин төгөлдөр шийдвэрийг үгүйсгэж, хэргийг сэргээхээр хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ." гэсэн заалтыг зөрчиж, шүүх эрх мэдэлд халджээ.

Иймд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн байна." гэсэн агуулгатай мэдээлэл ирүүлжээ.

Дөрөв. Нийслэлийн Баянгол дүүргийн 9 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Мэргэн Үндсэн хуулийн цэцэд хандан:

"Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2, 3 дугаар зүйл нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Аравдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг дараах үндэслэлээр тус тус зөрчсөн гэж үзэхээр байна.

1.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар зөвхөн Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар

бүлэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд шалгаж байгаад тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийн дагуу хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон гэмт хэргийг сэргээн шалгах аар зохицуулсан нь Үндсэн хуульд заасан тэгш байдлын зарчмыг үгүйсгэж, холбогдох этгээдүүдийг ялгаварлан гадуурхаж байгаа явдал юм. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйл нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн суурь зарчим болсон зүйл, хэсэг, заалттай нийцэхгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан;”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад энэ зүйлийн 1.1-д заасан нөхцөл байдал илэрвэл шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуустал нь явуулж, цагаатгах тогтоол гаргана.” гэж заасан.

2. Монгол Улс нэгдэн орж, соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлд “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. ...”, 26 дугаар зүйлд “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. ...” гэж заасан байдаг. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж заасан байх тул дээрх олон улсын гэрээг хэрэгжүүлэх нь манай улсын үүрэг билээ. Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль дээрх үндэслэлүүдээр зөрчсөн гэж үзэж байна.” гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлсэн байна.

Тав. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Оросоо, Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хорооны оршин суугч, иргэн Х.Нямдорж нар Үндсэн хуулийн цэцэгд хандан:

“1. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэргүүдийг буцаан шалгах нь эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмын хүрээнд боломжгүй. Энэ нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёс, ардчилсан ёс, тэгш байдлын зарчмыг зөрчиж байна. Мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд “... гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөрдөн байцаалтын болон шүүхийн

шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасантай зөрчилдөж байна.

2.Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон тохиолдолд үүнийг сэргээн шалгах хууль зүйн боломж байхгүй юм. Хөөн хэлэлцэх хугацааг буцааж тоолох хууль батлаад эргүүлээд иргэний эрх зүйн байдлыг дордуулсан хууль хэрэглэх эрх зүйн зохицуулалт нь Үндсэн хуультай зөрчилдөнө. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчиж байна. Монгол Улсын дээд шүүх нь хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн хүчин төгөлдөр тогтоолд шинээр үүссэн нөхцөл байдал тогтоогдвол хэргийг сэргээн шалгах зохицуулалт байхад хөөн хэлэлцэх хугацааг сэргээн хэрэглэх хууль зүйн үндэслэл байхгүй болно. Шүүх Үндсэн хуульд нийцсэн хууль хэрэглэх үүрэгтэй. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн уг зохицуулалт нь мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчиж байна.” гэсэн агуулга бүхий мэдээлэл ирүүлжээ.

Зургаа. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Баяраа Үндсэн хуулийн цэцэд хандан:

“Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар Эрүүгийн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байх үед хуульд заасан үндэслэлээр мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэргийн тухайд хожим Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулийг буцаан хэрэглэх замаар, эрүүгийн хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг хүндрүүлэх байдлаар гэмт хэрэгт ял шийтгэдэг жишиг тогтоох нөхцөл бүрдсэн байна. Аливаа хууль тогтоомжийг буцаан хэрэглэхдээ тухайн хуулийн үйлчлэлд өртөж буй этгээдийн эрх зүйн байдлыг дордуулбал буцаан хэрэглэхгүй, харин эсрэгээр дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэх нь зөвхөн эрүүгийн эрх зүйн төдийгүй иргэн, захиргаа бусад төрлийн маргаанд ч нийтлэг үйлчилдэг эрх зүйн суурь зарчим юм. Гэтэл Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2, 3 дугаар зүйлд нэгэнт шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хуульд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэргийг дахин сэргээн шалгах, мөн дуусаагүй эрүүгийн хэргийн тухайд өмнөх хуулийн

үйлчлэлээр хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй буюу Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх журам үйлчлэхгүй гэсэн байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар "... хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгана." гэснээр амьд явах эрхийн эсрэг, эрүүл мэндийн эсрэг, халдашгүй байдлын эсрэг, өмчлөх эрхийн эсрэг, үндэсний аюулгүй байдлын эсрэг зэрэг бусад гэмт хэргүүдээс илэрхий ялгаварлаж, албан тушаал хашиж байсны хувиар алагчилж, тэгш байдлын зарчмыг алдагдуулсан байна. Мөн шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх, шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах тухай Үндсэн хуулийн зохицуулалтын дагуу нэгэнт тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн хүрээнд шийдвэрлэгдсэн хэрэг маргааныг Улсын Их Хурал дахин хууль баталж, шинээр батлагдсан хуулиа эрүүгийн хэргийн оролцогчдын эрх зүйн байдлыг дордуулах замаар хэрэгжүүлэхийг шүүх эрх мэдлийн байгууллагад тулгаж байгаа нь Үндсэн хуулийн шууд зөрчил юм.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Дөчин долдугаар зүйлийн 1, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн тухай дүгнэлт гаргаж өгөхийг хүсье." гэсэн агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ.

Долоо. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбарт:

"1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:", мөн зүйлийн 1 дэх заалтад "хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;" гэж заасан. Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхийн хүрээнд төрийн аливаа бодлого шийдвэрийг гаргадаг төдийгүй үүнтэй адил олон шийдвэр гаргаж байсан. Түүнчлэн авлига, албан тушаалын гэмт хэрэг нь улс орон, олон нийтийн эрх ашгийг хохироож, бусдад давуу байдал олгож, хүнд хор хохирол учруулж байдаг гэмт хэрэг тул хууль тогтоогчид Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлгийн гэмт хэргийг сэргээн шалгах нь зүйтэй гэж үзсэн болно.

2.Хууль олон салаа утгагүй нэг мөр ойлгогдох, иргэд олон нийтийн хүсэл зорилгод нийцэж, шударга ёсыг тогтоох нийгмийн



шаардлагад үндэслэгдэх учиртай. Хууль тогтоогчид хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг батлахдаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэсэн эсэх, хэл зүй, найруулгын нийтлэг шаардлага хангасан эсэх, нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлсэн эсэх гэх зэрэг тал бүрээс нь судалж, олон шат дарааллын дагуу хэлэлцэн баталдаг. Монгол Улс 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авилгалын эсрэг конвенцод нэгдэн орсон бөгөөд тус конвенцын 30 дугаар зүйлд “Оролцогч улс бүр өөрийн төрийн албан тушаалтанд чиг үүргээ гүйцэтгэхэд нь олгосон аливаа дархан эрх буюу шүүхийн харьяаллын давуу эрх болон энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийг шаардлагатай бол үр ашигтайгаар мөрдөн байцаах, яллах, ийм хэрэгт шүүхийн шийдвэр гаргах боломжийн хооронд зохих тэнцвэрийг эрх зүйн тогтолцоо болон үндсэн хуулийн зарчимдаа нийцүүлэн тогтоох буюу хадгалахад шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна.” гэж заасан хүрээнд хуулийг хэлэлцэн баталсан болно. Мөн хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалт буюу Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн зохицуулалт бол процессын хэм хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацаа тоолох журам нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан үнэт зүйл биш бөгөөд процессын шинж чанартай зохицуулалт тул Эрүүгийн хууль буцаан хэрэглэх зарчимд хамаарахгүй гэж үздэг.

3. Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай зөрчилдсөн, хийдэлтэй байсан тул зөрчил, хийдлийг зайлшгүй арилгах шаардлага үүссэн. Тухайлбал, Эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахын тулд мөрдөх байгууллага болон прокурорын зүгээс гэмт хэрэг үйлдсэн хүнийг шуурхай илрүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу тасралтгүй явуулах шаардлагатай бөгөөд хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж тогтоож чадаагүй бол эрүүгийн хэрэг үүсгэж, хэн нэгнийг яллагдагчаар татаж болохгүй, эсхүл нэгэнт яллагдагчаар татсаны дараа дээрх нөхцөл байдал тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх талаар Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой заасан байсан. Гэвч Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмыг хэрэглэхэд практикт хүндрэлтэй асуудлууд гарсан.

Иймд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам нь харилцан зөрчилтэйгөөс гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай уялдаагүй байсан тул хууль болон зүйл, хэсэг хоорондын зөрчил хийдлийг арилгаж, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмыг ижил зарчмаар хуульчлах, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж өөрчлөх, хуулийн

этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тодорхой болгох бодит шаардлагыг харгалзан үзсэн болно. Дээр дурдсаныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчөөгүй байна.” гэжээ.

Найм. Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2020 оны 138 дугаар тогтоолын дагуу шинжээчээр томилогдсон Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Б.Батзориг дүгнэлтдээ:

“1.Эрүүгийн эрх зүй дэх “хөөн хэлэлцэх хугацаа” хэмээх нэр томъёоны хүлээн зөвшөөрөгдсөн агуулга болон үндсэн зарчмыг нийтлэг байдлаар хэрхэн тодорхойлдог болох:

БНМАУ-ын 1926, 1929 оны Шүүх цаазын бичигт “Ялыг үл хэлэлцэх”, 1934 оны Шүүх цаазын бичигт “Шүүх цаазын ёсоор хөөн байцааж үл болох шалтгаан”, 1942 оны Эрүүгийн хуульд “Хуулийн ёсоор хөөн шийтгэж үл болох шалтгаан” гэж тус тус хуульчлан томъёолж байсан. “Хөөн хэлэлцэх хугацаа” гэсэн томъёоллыг 1961 оны Эрүүгийн хуульд тусгаснаас хойш Эрүүгийн эрх зүйд ийнхүү нэрлэж хэвшсэн. Эдгээр хуульд гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш “Эрүүгийн хууль”-д заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй, эрүүгийн хариуцлагад татаж болохгүй, шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхгүй байх гэсэн утгаар тусгагджээ. Эрүүгийн болон Эрүүгийн процессын (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх) эрх зүй нь нэг талаас төр, нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Энэ утгаараа төр гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох зорилгоор гүйцэтгэх алба, мөрдөн шалгах байгууллага, прокурор болон бусад төрийн байгууллагын хүн хүч, техник хэрэгслийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ашигладаг. Энэ нь төрийн хууль сахиулах дэг журмыг тогтоохоос гадна эрх зөрчигдөн хохирсон хүн, хуулийн этгээдийг хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж буй үйл ажиллагааны илрэл. Нөгөө талаар төрд буй хүн хүч, техник хэрэгсэл, эрх мэдлийг хэн нэгэн хүн, хуулийн этгээдэд холбогдуулан хязгааргүй ашиглах боломжийг хуулиар зохицуулдаг. Энэхүү зохицуулалтын нэг хэлбэр нь “хөөн хэлэлцэх хугацаа” юм. Хөөн хэлэлцэх хугацаа нь бүхий л төрлийн эрх зүйн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг. Эрүүгийн эрх зүй дэх хөөн хэлэлцэх хугацаа нь бусад эрх зүйн маргаанаас ялгаатай. Бусад эрх зүйн маргаан ихэвчлэн ижил тэгш эрхтэй талуудын хооронд үүсдэг бол эрүүгийн эрх зүйд төрийн хууль сахиулах байгууллага, прокурор, шүүх болон иргэн, хуулийн этгээд гэсэн харьцуулахад төвөгтэй хүч тэнцвэргүй талуудын хооронд үүсдэгээрээ онцлог. Монголын эрх зүйн тогтолцооны онцлогоос хамаарсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хаалттай явагдах,



тэдгээрт тавих хяналт нь энэ ялгааг улам нэмэгдүүлдэг. Гэвч иргэн, төр хоёрын хооронд үүсэх харилцааг хуулиар нарийвчлан зохицуулах замаар зохицуулдаг. Тухайлбал, иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, гомдол гаргах эрх, төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах, тэдний гаргасан алдаа, дутагдлыг буруутгагдаж буй хүн, хуулийн этгээдэд ашигтай шийдвэрлэх, хөөн хэлэлцэх хугацаа дууссан тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ямар ч ажиллагаа явуулж болохгүй гэх мэт олон зохицуулалтыг дурдаж болно.

Хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн хэмээн сэжиглэх, яллах, гэм буруутайд тооцон шийтгэх ажиллагааг зөвхөн хуульд заасан хугацаагаар хязгаарладаг. Ийнхүү хөөн хэлэлцэх хугацааг хуулиар хязгаарлаж байгаа нь дараах нийтлэг зарчимтай нийцдэг. Үүнд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэж заасан нь төр хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэнд буруутган шалгах хугацааг хууль тогтоомжоор дамжуулан тогтоон илэрхийлж байгаа явдал. Энэхүү Эрүүгийн хуулиар тогтоосон хөөн хэлэлцэх хугацаа нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн онцлог, нийгмийн хор аюулын хэмжээ, шийтгэхээр заасан ялын төрөл, хугацаагаар ялгамжтай тогтоох ба зарим тохиолдолд хөөн хэлэлцэх хугацааг тоолдоггүй. Ийнхүү хуульчилснаар төр дур зоргоор ажиллах, хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах явдлыг хуулиар хязгаарлаж байгаа явдал мөн.

2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн онолын үндэслэл болон үйлчлэлийн шалгуурыг хэрхэн тодорхойлох тухай:

Энэхүү дүгнэлтийг гаргахын тулд Монгол Улсад батлагдсан "... дагаж мөрдөх журмын тухай" 38 хуулийг судлав. Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хамруулаагүй. Эдгээр хуульд байх нийтлэг шинж "тухайн хуулийн тодорхой заалт хэрэгжиж эхлэх хугацаа заасан, хүчингүй болсон хуулийн заалтыг тогтоосон хугацаанд хэрхэн хэрэглэх, өмнө хуулийн дагуу хийгдсэн ажиллагаа, авсан бүртгэл, зөвшөөрлийг батлагдсан хуультай хэрхэн нийцүүлэх арга, ажиллагааг заасан" байна. 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр, 2016 оны 5 дугаар сарын 13-ны өдөр тус тус батлагдсан "Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-д зөвхөн Эрүүгийн хуультай холбоотой харилцааг зохицуулсан байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан "Хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт"-д дүн шинжилгээ хийж үзэхэд зөвхөн "хуулийг, хууль бүхэлдээ, хууль хэрэгжүүлэхдээ, өмнө нь үйлчилж байсан хууль, хууль үйлчилж эхэлсэн, өмнөх хууль, эрх зүйн зохицуулалт, хууль буцаж үйлчлэх

онцгой тохиолдол” гэж заасан. Харин бусад хууль болон холбогдох хууль тогтоомж гэсэн агуулга илэрхийлээгүй байна.

Дүгнэлт, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөж журмын тухай хуулиар зөвхөн Эрүүгийн хуулийн үйлчлэлтэй холбоотой нийгмийн харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчин Монгол Улсад үйлчилж байна.

3. Эрүүгийн эрх зүйн хууль буцаан хэрэглэх зарчмыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах талаарх онолын үндэслэл:

Эрүүгийн эрх зүй дэх хууль буцаан хэрэглэх зарчим нь Эрүүгийн процесст дараах байдлаар хэрэглэгддэг. Үүнд:

I. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл;
II. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах хугацаа тогтоох;
III. Хэргийг хэрэгсэхгүй болгох, яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох;

IV. Шүүхийн шийдвэр гаргах;
V. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдах эсэх;

VI. Хэрэгтэн болон ялтан шилжүүлж өгөхөөс татгалзах;
VII. Хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа явуулах зэрэг тохиолдол.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн онцлог нь хатуу тогтоосон хэм хэмжээ. Энэ нь уг хуулийн 1.2 дугаар зүйлд заасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаараар илэрхийлэгдэнэ. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална.

- Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр, түүнд хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.

- Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүнд холбогдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад энэ хуульд заасан журмыг баримтална.

- Гадаад улсын, олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдэлж байгаа хүнийг яллагдагчаар татаж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах зөвшөөрлийг Улсын ерөнхий прокурор Монгол Улсын гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улс, олон улсын байгууллагаас хүснэ.

Эрүүгийн процесст бусад хууль тогтоомжийг ашиглахаар бол заавал тус хуульд дурддаг. Эрүүгийн процессын явцад хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, хууль хэрэгжүүлэгч, оролцогчийн санал, хүсэлтээр Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөнд халдаж нэгжлэг, хураан авах гэх мэт халдашгүй бусад эрхэд халддаг. Ийнхүү хатуу тогтоосон хэм хэмжээтэй байх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусад хуулиудын хийдэл, зөрчилдөөний улмаас хэрэгжүүлэгч болон оролцогчид дур зоргоороо авирлах, бусдын эрх зөрчигдөхөөс хамгаалах гол зохицуулалт болдог. Зарим судлаачид Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх, прокурор, мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина.” гэснийг бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа иш татан хэрэглэх зохицуулалт гэж үздэг. Энэ заалт нь шүүх, прокурор, мөрдөгч үйл ажиллагааны явцад Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомж зөрчихгүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулсан болон төрийн албан хаагчийн хувьд иргэнийхээ хувьд мөрдөх бусад хууль тогтоомж мөрдөх агуулгыг илэрхийлсэн. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хязгаарлагдана.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ.” гэсэн заалт хуулийг буцаан хэрэглэхэд баримтлах үндсэн зарчмын зохицуулалт юм.

Дүгнэлт, Эрүүгийн хууль болон Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зүйл, заалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдаагүй бол Эрүүгийн процесст оролцогчид ашиглах боломжгүй.” гэсэн байна.

Ес. Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар дээрх маргааныг хэлэлцэж 02 дугаар дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“Монгол Улсын Их Хурал 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, үүнтэй уялдуулан тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг мөн баталжээ.

Хууль тогтоогч Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2 дугаар зүйлээр 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр мөрдөн байцаалтын шатанд прокурорын тогтоолоор, мөн хугацаанд шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгахаар, түүнчлэн 3 дугаар зүйлээр дээрх хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй байхаар заасан байна.

Ийнхүү хуульчилсан нь дараах үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Удиртгал хэсэгт хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон тунхагласан билээ. Мөн уг хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

Гэтэл хууль тогтоогч дээр дурдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хуулийн дагуу эрх бүхий этгээд болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээн шалгахаар тогтоосон нь иргэдийн эрх зүйн байдлыг дордуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Энэ нь эрх зүйн тодорхой байдлыг тогтоож, хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх төрийн үүрэг болон дээр дурдсан Үндсэн хуулийн суурь зарчмыг зөрчиж,



улмаар Үндсэн хуулиар тунхагласан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны үзэл баримтлалд харшилж байна.

2.Мөн тухайн хуулиар зөвхөн тодорхой төрлийн гэмт хэргийг буюу Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгахгаар тусгасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлийг бүрдүүлсэн байна. Ийнхүү Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой төрлийн гэмт хэргийг тухайлан зааж өөр журам тогтоосон нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдын эрх тэгш байх зарчмыг хууль батлах замаар зөрчих буруу жишиг тогтох үр дагавартайг дурдах нь зүйтэй юм.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж заасан бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. ...”, мөн зүйлийн 7 дахь хэсэгт “Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй.”, мөн 26 дугаар зүйлд “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. ...” гэж тус тус заажээ.

Энэ хүрээнд гишүүн орнуудын хүлээвэл зохих үүрэг нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад хүнд, хөнгөн ямар ч хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж байгаагаас үл хамаарч хуулийн өмнө адил тэгш хамгаалалт, нөхцөлөөр хангагдах, эрх зүйн ямар нэг зохицуулалтаар ялгаварлагдахгүй байх ёстой юм. Дээр дурдсан зарчмууд нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.”, 1.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, оногдуулах ялыг хөнгөрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ.”, 2 дахь хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.”, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль,

энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ.” гэж баталгаажсан байна.

Үүнээс үзэхэд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн агуулга нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тэгш эрхийн зарчим болон хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй талаарх заалтыг хөндсөн гэж үзэхээр байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж заасантай харшилжээ.

4.Аливаа хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулиар зөвхөн тухайн хуулийн үйлчлэлтэй холбоотой нийгмийн харилцааг зохицуулдаг. Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулах асуудлыг тодорхой зааж хуульчилсан.

Эрүүгийн процессын эрх зүйн онол, хэм хэмжээний үзэл баримтлалын дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, хөндөх тохиолдол бусад салбартай харьцуулахад их байдаг тул уг онцлогтой уялдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх харилцааг төрөлжсөн хуулиар тусгайлан зохицуулдаг бөгөөд уг ажиллагаанд хамаарах хэм хэмжээг тус хуулиар тогтоох, эсхүл заавал эш татан хуульчилдаг болно. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зүйл, заалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгаагүй бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх боломжгүй юм. Гэтэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах агуулгатай зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгахгүйгээр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай дээрх хуулиар тогтоожээ.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг зөрчсөний зэрэгцээ, эрх зүйн суурь онолд нийцээгүй болно.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар



зүйлийн 14 дэх заалт, Дөчин долдугаар зүйлийн 1, 2, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн гэж үзэхээргүй байна.” гэсэн байна.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт:

“1.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Дөчин долдугаар зүйлийн 1, 2, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

3.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй. ...” гэсэн болно.

Арав. Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг хэлэлцээд, 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр “Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлтийн тухай” 02 дугаар тогтоол гаргасан байна. Үүнд:

“1.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар

зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэсэн болно.

Арван нэг. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.”, мөн зүйлийн 1 дэх заалтад “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэж заасан. Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн аливаа бодлого шийдвэрийг гаргадаг төдийгүй үүнтэй адил олон шийдвэр гаргаж байсан. Түүнчлэн авлига, албан тушаалын гэмт хэрэг нь улс орон, олон нийтийн эрх ашгийг хохироож, бусдад давуу байдал олгож хүнд хор хохирол учруулж байдаг гэмт хэрэг тул хууль тогтоогчид Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлгийн гэмт хэргийг сэргээн шалгах нь зүйтэй гэж үзсэн болно.

2.Монгол Улс 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авилгалын эсрэг конвенцод нэгдэн орсон бөгөөд тус конвенцын 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Оролцогч улс бүр өөрийн төрийн албан тушаалтанд чиг үүргээ гүйцэтгэхэд нь олгосон аливаа дархан эрх буюу шүүхийн харьяаллын давуу эрх болон энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийг шаардлагатай бол үр ашигтайгаар мөрдөн байцаах, яллах, ийм хэрэгт шүүхийн шийдвэр гаргах боломжийн хооронд зохих тэнцвэрийг эрх зүйн тогтолцоо болон үндсэн хуулийн зарчимдаа нийцүүлэн тогтоох буюу хадгалахад шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна.” гэж заасан хүрээнд хуулийг хэлэлцэн баталсан болно. Мөн хөөн хэлэлцэх хугацааг зохицуулалт буюу Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн зохицуулалт бол процессын хэм хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, хөөн хэлэлцэх хугацаа тоолох журам нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан үнэт зүйл биш бөгөөд процессын шинж чанартай



зохицуулалт тул Эрүүгийн хууль буцаан хэрэглэх зарчимд хамаарахгүй гэж үздэг.

3. Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуультай зөрчилдсөн, хийдэлтэй байсан тул зөрчил, хийдлийг зайлшгүй арилгах шаардлага үүссэн. Тухайлбал, Эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахын тулд мөрдөх байгууллага болон прокурорын зүгээс гэмт хэрэг үйлдсэн хүнийг шуурхай илрүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан журмын дагуу тасралтгүй явуулах шаардлагатай бөгөөд хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж тогтоож чадаагүй бол эрүүгийн хэрэг үүсгэж, хэн нэгнийг яллагдагчаар татаж болохгүй, эсхүл нэгэнт яллагдагчаар татсаны дараа дээрх нөхцөл байдал тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх талаар Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой заасан байсан. Гэвч Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмыг хэрэглэхэд практикт хүндрэлтэй асуудлууд гарсан.

Иймд Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам нь харилцан зөрчилтэйгөөс гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай уялдаагүй байсан тул хууль болон зүйл, хэсэг хоорондын зөрчил хийдлийг арилгаж, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд хөөн хэлэлцэх хугацаа тоолох журмыг ижил зарчмаар хуульчлах, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг нэмэгдүүлж өөрчлөх, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тодорхой болгох бодит шаардлагыг харгалзан үзсэн болно. Дээр дурдсаныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх

... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй тогтоол гаргасан бол түүний үндэслэлийг Цэц бүрэн бүрэлдэхүүнтэй хуралдаанаар маргааныг эхнээс нь дахин хэлэлцэж, Улсын Их Хурал дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэл зөв болох нь нотлогдвол өмнөх дүгнэлтээ хүчингүй болгох, хэрэв үндэслэл нь батлагдахгүй бол Улсын Их Хурлын тогтоолыг хүчингүй болгож тогтоол гаргана.” гэж заажээ. Гэвч Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар тогтоолд Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа үндэслэлээ заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1.Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал ...-г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул уг хуулийг баталсан өдрөөс хүчингүй болгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлтийн тухай” 02 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.



3.Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Н.ЧИНБАТ

Д.СОЛОНГО

Д.ОДБАЯР

Б.БУЯНДЭЛГЭР

Ш.СОЛОНГО

Ц.НАНЗАДДОРЖ

Г.БАЯСГАЛАН

Ж.ЭРДЭНЭБУЛГАН

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 200003